

МОНГОЛЫН ТӨРИЙН АЛТАН АРГАМЖ: ТҮҮХ БА ОРЧИН ҮЕ

*Л.Хайсандай**

Түүхийн үүднээс үзэхүл Монголын дипломат албаны түүхэн замнал нь энэхүү алаг хорвоод алдаршин мандаж, бас алдарч уруудаж, ахин сэргэж өөдлөсөн манай үндэсний их төр улсын аугаа их түүхтэй амин холбоотой бөлгөө.

Чухамдаа туурга тусгаар алив төр улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа нь тухайн улс үндэстний язгуур эрх ашгаар тодорхойлогдож байдаг онцлогтой. Онолоор бол тийм юм. Өөрөөр хэлвэл алив улс орны гадаад бодлого нь тухайн улсын үндэсний эрх ашгийг тусган илэрхийлж, батлан хамгаалж, үйл хэрэгтээ мөрдлөг болгож байдаг жамтай. Энэ жам ёс, зүй тогтлын дагуу Монгол улс үндэстэн өөрийн гэсэн эрх ашигтай бөгөөд түүнийгээ өмөөрөн хамгаалсаар иржээ.

Тэрхүү эрх ашиг нь бүүр МЭӨ 200-аад оны үеэс өөрийн төр ёс, цааз эрхэмжийг тогтоож байсан Хүннү, Сүннү нарын цадиг түүхээс эхтэй, улбаатай гэдгийг манай эрдэмтэн судлаачид нотложээ. Энэхүү түүхийн баларшгүй ул мөрийг улам тодруулж өгсөн түүхт үйл явдалд XIII зууны эхээр ухаант, чин зоригт Тэмүүжин нүүдэлчин олон Монгол овог угсаатнаа нэгтгэж, Их Монгол улсаа байгуулсан их үйл хэрэг зүй ёсоор орно. Энэ нь Төв Азийг төдийгүй бүх Ази, Араб, Европ дахиныг нойрсноос нь сэрээж, аугаа их хөдлөл, хөдөлгөөнд оруулсан түүхэн үйл явдал байв.

Тийнхүү XIII зууны эхээр Монголын нэгдсэн төр улс, нэгдмэл монгол үндэстэн бий болсон тэр цагаас улс үндэсний язгуур эрх ашиг жинхэнэ ёсоор бүрэлдэн тогтсон гэж болно.

Монголын төр улсын үндэсний эрх ашиг нь манай нэртэй түүхч-эрдэмтэн, академич Ш.Бирагийн бичсэнчлэн тэнгэрийн үзэл буюу тэнгэризмээс эх сурвалж, үүдэлтэй байж болох юм. Энэ үзэл санааг зөв гэж үзэхийн учир гэвэл: Монголын үндэсний язгуур эрх ашиг нь Монголчууд болон Төв Азийн нүүдэлчид эрт дээр үеэс хэрэглэж ирсэн эртний Энэтхэгийн махбодийн онолтой ямар нэгэн байдлаар амин холбоотой байж болох талтай байна.

* Л.Хайсандай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

Эртний Энэтхэг, Түрэг, Уйгур, Төвдөөр дамжин Монголд орж ирсэн “мандлын” буюу “махбодийн” онолоор бол ертөнцийг буй болгогч нь “хий”, “гал”, “ус”, “шороо” хэмээх 4 язгуур махбодь байх бөгөөд түүнийг хар, шар, улаан, цагаан өнгөөр төлөөлүүлдэг байж. Эдгээр 4 махбодийн хөдлөх орон зай нь огторгуй мандал болох бөгөөд тэр нь хөх өнгөтэй байх.

Хөх өнгө нь махбодийг төлөөлсөн бүх өнгийн дэвсгэр буюу ерөнхий гол өнгө болдог учир Монголыг 4 махбодийн хөдөлж хөгжих орон зай нь болсон тэнгэр огторгуй буюу хөх өнгөөр төлөөлүүлж байжээ.

Ийнхүү хөх тэнгэр, хөх Монгол хэмээх нэр томъёолол хоорондоо утга агуулгын гүн холбоотой болж XIII зуунд улам өргөн хэрэглэгдэх болжээ. Дээр өгүүлсэн эртний Энэтхэгийн дөрвөн язгуур махбодийн онолоос үүдэн Монгол улсын үндэсний язгуур 4 эрх ашгийг доор дурьдсанаар томъёолон тодорхойлж болох юм гэж бодно.

Энэ нь нэгд, Гаднын аюул заналгүй оршин тогтнох эрх ашиг; хоёрт, улс үндэстнээ бүх талаар хөгжүүлэх эрх ашиг; гуравт, үндэсний түүх, соёлоо өвлөж бадруулах эрх ашиг; дөрөвт, улс үндсээрээ эв нэгдэлтэй нэгдмэл байх эрх ашиг мөн болой. Энэ 4 бүлэг эрх ашгийг үндэсний язгуур эрх ашиг хэмээх бөгөөд эдгээр нь өөр хоорондоо нягт уялдаатай, харилцан шүтэлцээтэй, харилцан бие биенээсээ хамааралтай нэгдмэл цогц юм. Эдгээр нь бас тус бүрдээ дотроо хэд хэдэн зүйлийн эрх ашгаас бүрэлдсэн бүтэцтэй байна. Эдгээр үндсэн эрх ашигт манай гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа ерөнхийдээ тулгуурлаж ирсэн ба тулгуурлаж ч байна гэж хэлж болно. Энэ нь чухамхүү их эзэн хаан Чингисийн үед буюу Их Монгол улсын үед л жинхэнэ ёсоор хэрэгжин төлөвшиж байжээ.

Чингис хаан элчин харилцааг хамгийн чухалд үзэж, “Элчин харилцаа бол Монгол төрийн алтан аргамж мөн” хэмээн айлдвар буулгаж, түүнийгээ чанад даган баримталдаг байж. Тийнхүү энэ алтан аргамжны амин гол үзэл санаа тулгуур зарчим нь дээр миний өгүүлсэн 4 бүлэг үндэсний язгуур эрх ашиг болж байжээ. Энэ үзэл номлолынхоо дагуу гадаад улсуудтай өргөн харилцаж, гэрээ, хэлэлцээ байгуулж, элч төлөөлөгчид олноор нь солилцож байсан аж. Тэр үед элч нарт их анхаарал тавьдаг, тэдний ажил төрөлд нь тус дэмжлэг үзүүлэн хүндэтгэлтэй ханддаг байж.

Гадаадын элчийг хүлээн авах, үйлчлэх, хаанд бараалхуулах, үдэж мордуулах нарийн дэг журам, ёс горимтой байж. Хааны илгээлт бичиг захидлыг тодорхой үг хэллэг, хэлбэр маяг, дэс дарааллаар бэлтгэдэг тусгай түшмэд, бичдэг бичээч, орчуулдаг орчуулагчтай байдаг байсан

гэх мэт. Ингээд бодоход Монголын дипломат алба өнө эртний уламжлалтай, эзэн Чингисийн үеэс улбаатай нь тодорхой.

Нөгөөтэйгүүр өнөөгийн улс хоорондын харилцааны зарчим, хэм хэмжээнүүд ямар нэг байдлаар бүүр тэр үед хэрэгжиж биеллээ олж байсан нь төвөггүй ажиглагдана. Энэ бүхнээс товч тоймлон дүгнэвээс:

Эзэн Чингисийн ба түүний дараа дараагийн үеийн түүхийн олон үйл явдлаас харахад Монголчууд бид улс үндэснийхээ эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, нэгдэн нягтарч байсан үедээ хүчирхэг улс, эзэнт том гүрэн болж ч явсан, харин улс үндэснийхээ эрх ашгийг огоорч, өөр хоорондоо хагаралдан тэмцэлдэж, задран бутрах болсон үедээ бусдын эрхшээл дор орж, дорой буурайн туйлд хүрч, үндэстнийхээ хувьд сөнөж мөхөхийн ирмэгт тулж очиж ч байв. Үүний тод жишээ гэвэл манжийн ноёрхол дор орж, 200 гаруй жил талхигдан мөлжигдөж байсан явдал юм. Энэ бүхэн бол бидний Монголын түүхэн бодит үнэн, бас түүхийн гашуун сургамж мөн билээ.

Харин ХХ зуун бол Монголчууд бидний хувьд эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлсэн зуун байлаа. Эл их үйлийн эхлэлийг Манжийн ноёрхлыг эсэргүүцэн нийт Монгол даяар өрнөсөн хүчирхэг тэмцэл хөдөлгөөний үр дүнд ялсан 1911 оны үндэсний хувьсгал тавьсан юм. Үүний нэгэн нотолгоо гэвэл 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монгол улсын хаан ширээнд үндэсний хувьсгалын үйл хэргийг гуйвалтгүй дэмжин “манлайлсан” Богд Жавзандамба хутагтыг залах төрийн их ёслол болж, түүнд төрийн тамга, өргөмжлөлийг өргөн барьжээ. Энэ бол Монгол улс Манжаас салж тусгаар улс болсноо тунхаглан зарласны илэрхийлэл байлаа. Мөн өдөр “Богдыг Монгол Улсын Наран гэрэлт, Түмэн наст Богд эзэн хаан хэмээн өргөмжлөн, Эрдэнийн сууринд залж, суулгаад, оны цолыг олноо өргөмжилсөн, Их Хүрээг Нийслэл Хүрээ хэмээн нэрлэж, дундаа соёмбо үсэгтэй шар торгоор хийсэн далбаа бүхий Монголын тулгар төр нээсэн тухай” даяар олноо зарлан тунхаглажээ.

Богд Жавзандамба лам Монгол улсын хаан ширээнд ёслол суухдаа их төрийн хэргийг эрхлүүлэхээр таван яам байгуулсаны нэг нь энэ өдрүүдэд 95 жилийн ойгоо тэмдэглэж буй (тэр үеийнхээр) Гадаад хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яам буюу одоогийн Гадаад хэргийн яам болой. Мөн өдрөө буюу олноо өргөгдсөн тэргүүн оны 11 дүгээр сарын шинийн 9-ний өдрийн морин цагт төрийн таван яамны сайд түшмэдийг Богд эзэн хааны зарлигаар тохоон томилсон байна. Үүнд тус Яамны анхны тэргүүн сайдад Чин ван Ханддоржийг томилжээ.

Гадаад яамны сайд Чин ван Ханддорж хоёр дэд сайдынхаа хамт тангараг өргөхдөө: “Шашин, төрийн тулд зүтгэхэд хялбарыг эрэхгүй, бэрхээс зайлахгүй, өдгөөгийн байгуулсан төрийн тулд энэхүү батлан тогтоосон тангараг сахилгыг нүдний цөцгий, зүрхний тольт мэт хичээнгүйлэн хайрлана” хэмээн хэлсэн нь буй.

Богд хааны зарлигаар яамдыг дэслэсэн байна. Үүнд: Дотоод яамыг бусдаас тэргүүн зэрэгт тавьж, түүний сайд нь нэг ёсоор Засгийн газрын тэргүүний үүрэг гүйцэтгэхээр болжээ. Харин гадаад яамыг түүний дараа буюу дэд зэрэгт хамааруулжээ. Бүпцийн хувьд 3 үндсэн хэлтэстэй байхаар болжээ. Үүнд: Яамны өмнөд хэлтэс нь Дундат иргэн улстай холбогдох хэргийг, умарт хэлтэс нь Хаант Орос улстай харилцах асуудлыг, Төв хэлтэс нь бусад яамдтай гадаад харилцааны зарим хэргээр зөвлөлдөн нийлж хэлэлцэх явдлыг тус тус эрхлэх болсон ба эрхэлж байв.

Шашин, төрийг хосолсон хэмжээгүй эрхт хаант ёс тогтсоны шинж тэмдэг төрийн төв байгууллагын ажлын агуулга, хэлбэрт тодорхой тусгал илрэлээ олж байв. Тухайлбал, Сангийн яам Намсрай бурханыг, Цэргийн яам Жамсран, Гадаад яам Хор номхотгогч Аюуш бурханыг шүтээн болгодог байж. Энэ бүхэн бол зөвхөн дотоод талын байдал, асуудал.

Хамгийн гол нь гадаад нөхцөл байдал, хандлага харилцаа чухлаас чухал байв. Тиймд Богд хааны Засгийн газар бүүр анхнаасаа Монгол төрийн алтан аргамжны үзэл санааны дагуу улсынхаа тусгаар тогтнолыг гадаад улсуудаар хүлээн зөвшөөрүүлэх, тэдэнтэй дипломатын болон худалдааны, бусад талын харилцаа тогтоохыг эрмэлзэж, багагүй хүчин чармайлт тавьж байжээ. Юуны өмнө Умард, Өмнөд хоёр хөрштэйгээ бие даасан улсын хувиар найрсаг харилцаа холбоо тогтоож бэхжүүлэхэд чиглэсэн дипломат гадаад бодлого явуулсан байдаг. Гэтэл тэр бүх санал санаачлага, хүчин чармайлт “хад мөргөсөн” мэт талаар болж байлаа. Чухамдаа Монголын энэхүү тусгаар тогтнол хир зэрэг бат оршин тогтнох, цаашид бэхжин батжих эсэх нь гагцхүү тэр үеийн олон улсын нөхцөл байдал, нэн ялангуяа Монголыг тойрон хүрээлсэн гадаад орчны хандлага, харилцаанаас гол төлөв шалтгаалж байв. 1911 оны Монголын үндэсний хувьсгалын дараах үе бол дэлхийн хүчирхэг орнууд дэлхий дахиныг өөрсдийн хүчин чадлын хэрээр дахин хувааж, нөлөөний газруудыг нэмэн олж авах хүсэл эрмэлзлэл, үйл ажиллагаа ид өрнөж байсан үе байлаа.

Монголын хойт хөрш Хаант Орос улс олон улсын энэ бодлогыг бүрэлдүүлэхэд идэвхитэй оролцож, урьд олсон нөлөөний газраа хадгалж, шинээр нэмж олж авахыг зорьж байжээ. Өмнөд хөрш оронд Манжийн ноёрхол төгсгөл болж, дөнгөж байгуулагдсан Дундат Иргэн

улс Манжийн төр, түүний эрх мэдэл, эзэмшил бүхнийг өвлөн авагч болохыг илүүтэй санаархаж байлаа. Ийм нөхцөл байдалд Гадаад явдлын яамны сайд Чин ван Ханддорж болон төрийн бусад зүтгэлтнүүдийн дипломат арга ухаан, идэвхтэй хүчин зүтгэлийн ачаар Хаант Орос улстай 1912 оны 11 дүгээр сарын 3-нд хэлэлцээр хийж, Найрамдлын гэрээ байгуулж чадсан юм. Энэ нь Монгол улсын хувьд улс төрийн чухал ач холбогдолтой байв. Учир нь шинэ тутам тусгаар тогтносон Монгол улстай ийм гэрээ байгуулсан явдал түүний бие даасан байдлыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн хэрэг байлаа.

Энэ гэрээ нь Монгол улс тусгаар тогтнолоо тунхаглан зарласнаас хойш Монгол улсын олон улсын харилцаанд эзлэх статусыг тодорхойлоход хууль эрхийн анхны бодитой баримт бичиг болсон юм.

Хаант Орос, Монгол улс хоёр хоорондоо найрамдлын гэрээ, худалдааны протокол байгуулсан нь Монголыг урьдын адил дангаар эзэрхэх гэсэн Хятадын санаархалд цохилт болж, Оростой Монголын асуудлаар хэлэлцээ хийхэд хүргэжээ. Ийнхүү Орос, Хятадууд өөр хоорондоо хэд хэдэн удаа нот бичиг солилцож, өөр өөрсдийн байр суурийг илэрхийлж, санал нэгдэн Монголын асуудлаар хэлэлцээр хийхээр харилцан тохиролцжээ.

1914-1915 онд Хаант Орос, Дундат Иргэн хоёр гүрэн шинэ тутам тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан Монголын төлөөлөгчдийг арга буюу оролцуулан Хиагтад гурван этгээдийн хэлэлцээр хийсэн нь ХХ зууны эхэн үеийн олон улсын харилцаанд гарсан ховор тохиолдлын нэг болов. Хиагтын гурван улсын гэрээгээр Орос, Хятад хоёр их гүрэн өөрсдийн эрх ашиг, гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ямар нэгэн хэмжээгээр нийцсэн байдлаар Монголын оршин тогтнох хэлбэр хийгээд дотоод, гадаад эрхийн хэм хэмжээг тогтоосноор Монгол улсын олон улсын статус тодорхойлогджээ. Энэ тухай түүхч-эрдэмтэн О.Батсайхан бичсэн нь: “Хиагтын гэрээ бол нэг талаас хүчирхэг нь буурайгаа дарлах, өөрийн эрх ашигт захируулсан зүйл болсон хэмээн хэлж болох боловч нөгөө талаас нь авч үзвэл хоёр хүчирхэг улсын Монгол дахь ашиг сонирхлын огтолцол дээр Монголын тал өөрийгөө хамгаалан үлдэх, Монголыг нэг улсын доторх бус олон улсын субъектын түвшинд хүргэх хэтийн төлөв бүхий алхам хийснээр өвөрмөц онцлогтой болсон юм” гэсэн байна. Үүний дараа дараагаар ямар үйл явдал болов гэх мэтээр Монголын түүхийн бүхий л асуудлыг би энд ярих шаардлагагүй. Зөвхөн дипломат үйл ажиллагаатай холбогдолтой гол гол зүйлийн талаар товч тоймлон хэлье гэж бодож байна. Болгоож байгаа буй заа.

1921 онд үндэсний ардчилсан хувьсгал ялж, ардын эрхт засаг тогтсон нь Монголын тусгаар тогтнолын үйл хэрэгт шинэ үеийг нээсэн.

Нэрт монголч эрдэмтэн Оуэн Латтиморын томъёолсноор дорно зүгийн “эрх чөлөөний эвсэл” (Freedom Bloc) -ийн эхний нэг гишүүн нь болжээ.

Ардын Засгийн газраас гадаад бодлогын талаар авч явуулсан анхны арга хэмжээ нь 1921 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр гаргасан тунхаг юм. Уг тунхагт Дундат Иргэн улс, Зөвлөлт Орос улсын талаар Монголын ард түмэн, засгийн газрын баримталж буй байр суурийг илэрхийлж, тэдний зүгээс Монголтой эрх тэгш харилцаа тогтоохыг уриалсан байна. Мөн олон улстай гэрээ байгуулан, худалдаа арилжааг нэвтрүүлэхийг эрмэлзэж буйгаа мэдэгджээ. Энэ гадаад бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор 1921 оны 10 дугаар сард Монголын ардын засгийн газрын төлөөлөгчдийг (С.Данзан, Д.Сүхбаатар, Б.Цэрэндорж нарын зэрэг хүмүүсийн бүрэлдэхүүнтэй) ЗОУ-тай найрамдлын барилдлага байгуулж, дипломат харилцаа тогтоох тухай хэлэлцээр хийлгэхээр Москвад илгээжээ. Монголын төлөөлөгчид Москвад очоод Засгийн газрынхаа өмнөөс ЗОУ-ын ГХЯ-нд 8 зүйлт санал бүхий албан бичиг гардуулан өгснөөс гадна хоёр талын харилцааны асуудлаар санал солилцсон хэд хэдэн хуралдаанд оролцсон байдаг. Оросын тал мөн сарын 29-ний өдрийн хуралдаан дээр Монголын төлөөлөгчдөд гардуулсан хариу бичигтээ Зөвлөлт Орос ба Монголын хооронд найрамдлын хэлэлцээр байгуулах санал нэг байгаагаа илэрхийлсэн байна.

Чингээд 1921 оны 11 дүгээр сарын 5-нд Монгол, Орос улсын хооронд найрамдлын барилдлага байгуулах тухай хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Энэ хэлэлцээрийн улс төрийн үндсэн агуулга нь Монголын ардын засгийг хүлээн зөвшөөрөх явдал байсан. Энэ нь Монголын түүхэнд их гүрэнтэй байгуулсан анхны хэлэлцээр болсон гэж үзэж болно. Уг хэлэлцээрээр хоёр талдаа бүрэн эрхт төлөөлөгч ба консулуудыг харилцан суулгахаар тогтсоны дагуу 1922 онд Монгол, Зөвлөлт Орос улс тус тусын нийслэлд элчин төлөөлөгчийн газраа нээж, бүрэн эрхт төлөөлөгчөө томилон суулгажээ. Энэ үйл явдал Монголын дипломат албаны түүхэнд шинэ хуудас нээсэн нь үнэн.

Монголын гадаад харилцааны үйл ажиллагаа олон жил (1921-1946)-ийн турш үнэн чанартаа зөвхөн Зөвлөлт улстай тогтоосон харилцааны хүрээгээр хязгаарлагдаж байв. Зөвлөлт улс ч Монгол улсыг дэлхий дахинд нээхийг нэг их хүсэхгүй байсан тал бий юм. Энэ нь түүний гадаад бодлогын стратегитай шууд хамаатай асуудал байсан болов уу.

Түүнчлэн БХК(б)Н-ын дээд удирдлага коминтерны гүйцэтгэх хороотой хамсан 1928 оноос 1940-өөд оны эхэн хүртэл БНМАУ-ын гадаад харилцааг түгжин хаах арга хэмжээг системтэй авч байсныг хоёр орны архивын материал тодорхой харуулж байна.

Үүний хамт ЗХУ-д ч, манайд ч Сталин тэргүүтэй Зөвлөлтийн “дотоодыг хамгаалах”-ынхны зохиомолоор бий болгосон хэлмэгдүүлэлтийн хар сүүдэр хорлонтойгоор тусч байв. Монголын олон зуун шилдэг сэхээтнүүд, тэдний дотор Гадаад явдлын сайд (Ерөнхий сайдын албыг давхар хашдаг) байсан Д.Бодоо, А.Амар, П.Г эндэн нарыг хилс хэрэгт тулган, Зөвлөлтөд аваачиж цаазалсан байдаг.

1921 оны үед Гадаад яаманд 40-өөд хүн ажиллаж байсан бол 1930 оны эцэс гэхэд тав, зургаахан хүн ажиллаж байв гэсэн баримт байдаг. Хэлмэгдүүлэлтийн жилүүдэд Монголын НАХЯ-нд 200-аад хүн ажилладаг байсны 140 орчим нь КГБ-ынхан байсан гэдэг. Энэ бүхнийг би энд дурсахдаа Зөвлөлтөөс Монголд туслаж байсан өгөөмөр их тусыг огтхон ч үгүйсгээгүй. Зөвлөлтөд тэр жилүүдээс эхлэн Монголын олон зуун, сүүлд социализмын үед хэдэн арван мянган хөвгүүд охид суралцаж дээд боловсрол, мэрэгжилтэй болж байсныг дурьдахад хангалттай. Тухайлвал дипломат албаны мэргэжлээр олон арван хүн Зөвлөлтийн Москва хотноо Олон улсын харилцааны дээд сургууль, Дипломатын дээд сургууль, сүүлд Дипломатын академид суралцаж төгсчээ. Анхны 7 хүн (С.Аварзэд, Ш.Бира, М.Дүгэрсүрэн, С.Лочин, Б.Намсрай, Т.Пүрэвжал, О.Хосбаяр) ОУХДС-д суралцаж төгсчээ. Тэдний дараагаар олон хүн ээлж дараалан суралцаж төгссөн бөгөөд тэд бүгд Монголын дипломат албыг хөгжүүлж бэхжүүлэх үйлсэд эзэмшсэн мэрэгжлийнхээ дагуу хүчин зүтгэжээ.

Монгол-Зөвлөлтийн харилцаа нь энэ хугацаанд 1939 оны Халх голын тулалдаан, ЗХУ-ын эх орны их дайн, 1945 оны чөлөөлөх дайны шалгуурыг хамсан, ханисан нэр төртэй давсан юм.

1945 оны 2 дугаар сард Ялгад болсон холбоотон гурван их гүрний уулзалтаас БНМАУ-ын тусгаар тогтнол (Гадаад Монголын статус-кво)-ыг хадгалах хамтын шийдвэр гаргасан билээ.

Энэ нь ЗХУ Японы эсрэг дайнд оролцохынхоо нэг нөхцөл болгож тавьснаас үүдэлтэй түүхэн учир холбогдолтой үйл явдал болсон. Энэ нь нөгөөтэйгүүр Чан Кайшигийнхны санаархалд цохилт болж, Японыг ялагдсаны дараагаар манай улсын тусгаар тогтнолыг арга буюу хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн байна.

Үргэлжлэл нь дараагийн дугаарт